

Дундговь аймгийн Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны үйл ажиллагааны тайлан

2017-12-18

Рашаант


2017 онд ИТХ-аар бүрэн эрхийнхээ дагуу хураамж тогтоож төсвийн орлогыг нэмэгдүүлэх, төсвийн тодотгол хийж хэмнэлттэй зарцуулах, Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг явуулах, хууль тогтоомжийг сурталчилах, иргэдийг мэдээллээр хангах, БИНХ-ын дарга, ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах талаар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр ажиллалаа.

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан

Сумын ИТХ нь 2017 онд ээлжит бус хурал 1, ээлжит 2 хуралдаан хийж 2017 оны “Төсвийн тодотгол”, “Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах тухай”, “Гэрийн тэжээвэр нохой, муур эзэмших журам”, “Сумын 2018 оны төсвийн төсөл”, “Сумын Засаг даргын 2018-2020 оны мөрийн хөтөлбөр”, “Сумын эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “2018 оны газар зохион байгуулалт, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө”, “Сумын байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”, “ИТХ-ын хуралдаанд асуудал санаачлан оруулах, хэлэлцүүлэх журам”, “ИТХ-ын төлөөлөгч асуулга, асуулт тавих, хариуг хэлэлцэх журам” /”тайлангийн хавсралт 2” хэсгээс үзнэ үү/ зэрэг асуудлуудыг хэлэлцэж батлан гаргалаа. ИТХ-аас 16 заалт бүхий 9 тогтоол гаргасан байна. Төлөөлөгчдөөс 10 санал шүүмжлэл гарсанаас хурлын шийдвэр, үйл ажиллагаандаа тусгаж ажилласан. Тогтоолыг агуулгаар нь ангилж үзвэл Төсөв хөрөнгө баталсан 2, журам баталсан 4, ГЗБТөлөвлөгөө баталсан 2, Мөрийн хөтөлбөр баталсан 1, үндсэн чиглэл баталсан 1, Тайланд үнэлэлт өгсөн-1 тогтоолыг тус тус гаргасан байна. *2018 онд ИТХ-аас нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан хэм хэмжээний актуудын биелэлтэнд мониторинг хийж амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг судлан сонсгол явуулж бодлого боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.*

2.Тэргүүлэгчдийн хурал, шийдвэрлэсэн асуудлууд

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2017 онд 8 удаа хуралдаж 62 заалт бүхий 40 тогтоол гаргасан байна. Тогтоолыг агуулгаар нь ангилвал шагнал 7, Дотоод ажил 6, нэрэмжит болгох 2, Сонгууль зохион байгуулах 3, Хөрөнгө актлах, бүртгэх, шилжүүлэх 10, Үндсэн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр батлах 3, СХС-тай холбоотой 4, Хууль тогтоомж хэрэгжүүлэх 5, журам 2, Ан агнуурын бүс нутаг тогтоох 1 тогтоол гаргасан байна. Тогтоолын ангиллын эзлэх хувийг харуулбал: Зураг №1



2017 оны байдлаар хяналтанд авч биелэлтийг тооцож байх 19 тогтоолын биелэлтийг гаргахад 15 нь биелэгдсэн, 1 дутуу биелэлттэй байна. Тогтоолын биелэлтийг хувиар харуулвал: Зураг №2



ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас уламжилсаны дагуу төрийн дээд шагнал “Алтангадас” одонгоор 4 хүн, “Хөдөлмөрийн хүндэт” медиалаар 3 хүн, “Алдарт эх” одонгоор 7 хүн шагнагдлаа.

2017 онд Тэргүүлэгчдийн хурлаар 33925242.33 төгрөгний эд хөрөнгийг бүртгэн авч, 12648359,2 төгрөгний эд хөрөнгийг акталж, 3055000 эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг шилжүүлж, 13700000 төгрөгний засварыг бүртгэн авсан байна.

ИТХ-ын даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг хэлмэгдэгсдээс үлдэж, хадгалагдаж ирсэн түүх соёлын өв болох шашны ном судар, эд зүйлсийг бүртгэн авч орон нутгийн өмчийн бүртгэлд тусгаж хамгаалалтанд авлаа.



2017 оны онцлог нь Ерөнхийлөгчийн сонгуулийн жил бөгөөд ИТХ-ын Тэргүүлэгчдээс Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төв, сонгогчдын тоог тогтоож сонгууль явуулах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Тэргүүлэгчдээс СХС-ийн зарцуулалт, эргэн төлөлтийг удаа дараа чиглэл өгснөөр шүүхийн эвлэрүүлэн жуучлах журмаар хэлцэгдэж хугацаат үүрэг өгөгдсөнөөр төлөлтөнд тодорхой ахиц гарсан. Энэ ажлын хүрээнд СХС-ийн зээлийн дээд хэмжээ, Төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналтын ажлын хэсгийг шинэчлэн баталлаа. 2017 онд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна.

2017 онд хийх ажлын төлөвлөгөөнд 40 асуудал төлөвлөснөөс 1 асуудал биелээгүй /Иргэний танхим ажиллуулах/ бөгөөд 90 хувийн биелэлттэй байна. ИТХ-ын ажлын албанаас 7 хоног бүр ажлаа төлөвлөж 7 хоногийн мэдээ, сарын шуурхай мэдээг гаргаж өгдөг. “БИНХ-ын даргын ажил дүгнэх журам”-ын дагуу БИНХ-ын дарга нарын ажлыг сар бүр дүгнэж урамшуулал олгож байна. Ажлын алба 4'844'894,1 төгрөгний эд хөрөнгө хариуцдаг бөгөөд эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтаа сайжруулж анхан шатны бүртгэлийг зааврын дагуу хөтлөн аудитийн шалгалтаар эд хөрөнгөтэй холбоотой зөрчил гараагүй.

Аймгийн мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагаанаас өгсөн зөвлөмжийн дагуу бичиг хэрэг, архивын ажлыг стандартын дагуу хийж төрөлжүүлэн сумын архивт шилжүүлж байна. ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор сумын Эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн Тэргүүний ажилтан Ц.Жанлавын нэрэмжит

болгохоор хүсэлт гаргаж аймгийн ИТХ-ын тогтоолоор Ц.Жанлавын нэрэмжит Эрүүл мэндийн төв болсон. Ахмадын баяр, Цагаан сараар байгууллагын харъяат 3 ахмадад хүндэтгэл үзүүлсэн. **Ажлын албанд 32 албан бичиг ирж хариутай 11 бичгийн хариуг өгсөн ба 40 бичиг явуулсан байна. Ирсэн явсан бичгийг цаасаар болон цахимаар үйлдэж байгаа** нь цаг алдахгүй байж удирдлагаас хяналт тавих боломжтой болсон. Шинээр сонгогдсон 21 төлөөлөгчийн ХОМ-ийг 2016 оны байдлаар маягтын дагуу авч нэгтгэн баталгаажуулж АТГ-т хүргүүлсэн. Төрийн албан хаагчийн урьдчилсан мэдүүлэг 21, шинээр ажилд томилогдсон 2 ажилтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч АТГ-т хүргүүлсэн.

Ажлын албанд 20 санал, хүсэлт ирсэнээс 1 хүсэлт бүрэн биелээгүй. Төрийн мэдээлэл, Нутгийн удирдлага, “Дундговийн амьдрал” сонинг ажлын албаны хэрэгцээнд тогтмол захиалж байна.

Гурав. Сургалт, сурталчилгаа, зохион байгуулсан ажлын талаар

Монгол улсын хууль, аймаг, сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрийг 6 БИНХ, мэдээллийн цагаар иргэдэд яриа, таниулга хэлбэрээр 40 удаа хийж давхардсан тоогоор 1200 иргэн хамрагдсан. ИТХ, Тэргүүлэгчдээс гарсан шийдвэр, цаг үеийн ажлыг мэдээллийн самбараар ил тод тогтмол мэдээлж, **Хурал.mn** сайтыг хөгжүүлж үндсэн цэс 4, дэд цэс 28-ыг шинээр буй болгож 50 мэдээ байршуулсан. Сайтыг хөгжүүлж, аймгийн цахим сайт, сумын фэйсбүүк группэд холбосноор хандалтын тоо 13000-д хүрээд байна. Энэхүү сайтыг хөгжүүлэх зорилгоор зарлагдсан уралдаанд амжилттай оролцож улсын хэмжээнд тэргүүн байр эзэлсэн. Төлөөлөгчид өөрийн цахим хуудсандаа орж мэдээлэл авч, өгч байхыг уриалж байна. 2017 онд хийж хэрэгжүүлсэн бүтээлч ажлын талаар “Дундговийн амьдрал” сонинд 1 нүүр хэвлүүлж 250 өрхөд хүргүүлсэн. Мөн “Нутгийн удирдлага” сэтгүүлд 1 нүүр хэвлүүлж сурталчиллаа.

2017 онд ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанаас тэтгэлэгт хөтөлбөр, хандив, тусламжаар нийт **9'772'000** төгрөгний дараах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүллээ. Үүнд:

1. 2017 оны 3 сарын 31-ны өдөр **“Олборлох үйлдвэрлэлийн ил, тод байдал”** сэдэвт уламжлалт нээлттэй хэлэлцүүлэг-өдөрлөг зохион байгуулж уул уурхайн ашиглалт, хайгуулын компаниудаас хийсэн болон төлөвлөсөн ажил, өгсөн хандив, тусламж, түүний зарцуулсан байдлыг нээлттэй хэлэлцлээ. Гурвалсан хэлэлцүүлэгт Уул уурхайн компаниуд, ЗДТГ, иргэдийн төлөөлөл, ТББ-ууд оролцлоо. Хэлэлцүүлгийн үеэр сумын төсвийн байгууллага, ТББ-ууд 2017 онд уул уурхайн ААН-үүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллалаа. Хэлэлцүүлэг, өдөрлөгөөс “Зөвлөмж” гаргасан. Зураг №1



2. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн “Төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн нэгжээс зарласан тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж **“Олборлох салбарт ИТХ-ын хяналтын чиг үүрэг”** сэдэвт **4,0 сая** төгрөгний төслийг амжилттай хэрэгжүүллээ. Тус төсөл, хөтөлбөрийн хүрээнд ашиглалтын лицензтэй 3, хайгуулын лицензтэй 3 компанид төлөөлөгчид газар дээр нь тусгай картаар хяналт, үнэлгээ хийж, хэлэлцүүлэг зохион байгуулж дүнг гаргалаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад хэлэлцүүлгүүдээс гарсан саналыг үндэслэн **“Суманд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ААН, байгууллагад ИТХ-аас хяналт тавих журам”** /”тайлангийн хавсралт 1” хэсгээс үзнэ үү/ боловсруулж ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлууллаа.



3. ” **2932000** төгрөгний зардалтай “**Төлөөлөгчийн манлайлал**” хөтөлбөр боловсруулж УБ хотод Нутгийн Удирдлагын холбоотой хамтран 16 төлөөлөгчийг 2 өдрийн сургалтанд хамруулж чадавхжуулан гарын авлагаар хангав.
4. ИТХ-ын Тэргүүлэгчдээс баталсан “**Шатар**” хөтөлбөрийн хүрээнд **1140000** төгрөгний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж 6 өдөрт 44 цагийн шатрын сургалтыг дэлхийн шатрын холбооны шүүгч, дасгалжуулагч М.Гантөгс зохион байгуулсан. Сургалтанд нийт 5-15 насны 30 хүүхэд хамрагдаж хүүхдүүдийн шатрын мэдлэг чадварыг дээшлүүлж “**Батламж**” олголоо. Сургалтын явцад Сургууль, Цэцэрлэгт сургалтын зориулалтаар шатрын ханын самбар олголоо.



5. “**Багийн иргэдийн нийтийн хурлын дотоод ажил**” **98000** төгрөгний хөтөлбөр хэрэгжүүлж 6 багийн ИНХ-ын дарга нарт 1 өдрийн сургалт явууллаа. Сургалтаар Нутгийн өөрөө удирдах ёсны тухай ойлголт, хуралдааны бэлтгэл ажил хангах, хуралдаан удирдах, бичиг хэргийн стандарт, архивийн нэгж байгуулах талаар хичээл заагдлаа.



6. 6 багийн БИНХ-ын дарга нарыг аймагт болсон 2 өдрийн сургалтанд хамруулж нутгийн удирдлагын талаархи мэдлэгийг дээшлүүлсэн.
7. Шинэ үндсэн хууль батлагдсан тэмдэглэлт өдрийг уламжлалын дагуу тэмдэглэж Төрийн тугийг ёслол төгөлдөр залж, Үндсэн хууль батлахад оролцсон хүмүүст мэндчилгээ дэвшүүлж, байгууллагын дунд “Центавр”, “АХА” зэрэг тэмцээн зохион байгуулав. Хүүхдүүдийн дунд шатрын тэмцээн зохион байгуулж, иргэний андгай өргөх үйл ажиллагаа явагдлаа.



8. “Наранцацралт сан”-гийн дэмжлэгтэйгээр БНСУ-ын Гояань хотын эрүүл мэндийн байгууллагын нарийн мэргэжлийн эмч нарыг урьж мэдрэл, дотор, уламжлалт эмнэлэг, хүүхдийн чиглэлээр үзлэг, оношлогоо хийгдлээ. Үзлэг оношлогоонд сумын 700 иргэн хамрагдаж, төрөл бүрийн витамин, амин дэмээр үнэ төлбөргүй хангагдлаа.




9. Нутгийн удирдлагын шинэ тогтолцоо үүсч, хөгжсөний 25 жилийн ойг тэмдэглэж үе үеийн ИТХ-ын дарга, Засаг дарга, нарийн бичгийн дарга нарыг урьж дурсамж, ярилцлага хийлээ. Ойн арга хэмжээний үеэр МНУХ-ны Тэргүүний ажилтан цол тэмдэг, МНУХ-ны дээд шагнал Соёмбо одонгоор ажлын өндөр амжилт үзүүлсэн, олон удаа иргэдийн итгэлийг хүлээж сонгогдсон төлөөлөгч, үе үеийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг шагнаж, хүндэтгэлийн тоглолт хийж, “АХА” тэмцээн зохион байгууллаа./1602000төг/



10. Сумын нутаг дэвсгэр дээр байршилтай уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй талбай, түүх соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газар, тусгай хамгаалалттай газар, малчдын өвөлжөө, хаваржаа, худаг, уст цэгийн байршлыг харуулсан **суурь судалгааны зураглал** хийлээ.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НУТАГ ДЭВСГЭР ДЭХ ЛИЦЕНЗИЙН ТАЛБАЙН ЗУРАГ



Дөрөв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар

Сумын иргэдэд “Гэмт хэрэг зөрчилгүй-Аюулгүй амар тайван орчин” сэдэвт өдөрлөг зохион байгуулж Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Эрүүгийн хуулиудаар сургалт хийж, иргэдэд хуулийн мэдлэг олголоо. Тус сургалтанд 65 иргэн хамрагдав.



Өдөрлөгийн үеэр аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах байцаагч цагдаагийн дэд хурандаа О.Чинзориг иргэд, жолооч нарт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар сургалт, дадлага ажил хийж, сумын төвд баригдаж буй шинэ засмал замын тэмдэг тэмдэглэгээг суурилуулах ажилд хяналт хийж, мэргэжлийн зөвлөгөө өгөв. Дунд ангийн сурагчдын дунд замын хөдөлгөөний анхан шатны мэдлэг олгох зорилго бүхий **“НОГООН ГЭРЭЛ-ЦАГААН ШУГАМ”** тэмцээн зохион байгуулав.



Цагдаагийн хэсэгт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын ОНХС-ийн **2'500'000** төгрөгийн санхүүжилтээр бэлэн бус торгуулийн POS машин, хэвлэгч, санхүүгийн бусад эх үүсвэрийн **2'500'000** төгрөгийн санхүүжилтээр нисдэг дрон камер зэрэг тоног төхөөрөмжүүдээр хангаж ажилласан нь орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэх хүү, торгуулийн орлого нэмэгдүүлэх боломж нэмэгдэж байна.



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийсэн ажилаа сумын фэйсбүүк хуудас, “Дундговийн амьдрал” сонинд нүүр гаргаж нийтэлсэн.



Иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа

№	Үйл ажиллагааны нэр, төрөл	Хамтарсан болон Зохион байгуулсан газар, хүн	Хамрагдсан хүний тоо	Зохион байгуулсан огноо
1	Үзүүлэх сургалт, хорт зуршлын тухай сургалт	Аймгийн Цагдаагийн газар, ГХУССЗ	100	III/18
2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн сургалт	ГХУССЗ, С.Батбаяр, НБМ Б.Оюунханд	70	V/15
3	Сумын төвийн айл өрхийн хэсгийн ахлагч нарт хийсэн зааварчилгаа	ГХУССЗ, Р.Мөнхбат, С.Батбаяр	12	VI сард
4	“Гэмт хэрэг зөрчилгүй-Аюулгүй амар тайван орчин” аяны сургалт	Аймгийн Цагдаагийн газар, ГХУССЗ	95	X сард
5	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай сургалт /ЕБС сурагчдад/	ГХУССЗ, С.Батбаяр	80	X сард

6	ЕБС-ийн сурагчдын дунд гар зураг, эссе бичлэгийн уралдаанууд	ГХУССЗ	100	Х сард
7	“Ногоон гэрэл-Цагаан шугам” тэмцээн /ЕБС/	ГХУССЗ	50	Х сард
	Хамрагдсан нийт хүний тоо /давхардсан тоогоор/		507	


Малчид, иргэдэд хүргүүлсэн сурталчилгааны материал

№	Тараасан материалын нэр	Тараасан тоо ширхэг
1	Малчидтай харилцах дэвтэр, санамж бичиг	27 өрхөд
2	Зөвлөмж, зарлан мэдээлэл	195 өрхөд
3	Сар шинийн Уриалга	150 өрхөд
4	Орон байрны хулгайн сэрэмжлүүлэг	12 өрхөд
5	Сумын ГХУССЗ-ийн фэйсбүүк группээр 15 төрлийн материал , шторкуудыг сурталчилсан	Иргэд, олон нийтэд
	Цаасаар тараасан материалын тоо	384

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан төсөв

	Хэрэгжүүлсэн ажлын нэр	Мөнгөн дүн ₮	Эх үүсвэр
	Монгол цэргийн баярт зориулсан үйл ажиллагаа	524.000	Иргэд, ААНБ-ын хандив, тусламж
	“Гэмт хэрэг, зөрчилгүй амар тайван амьдралын төлөө” аяны үйл ажиллагаа	200.000	ИТХурал
	“Цагдаа таны найдвартай түнш” үйл ажиллагаа	35.000	Иргэд, ААНБ-ын хандив, тусламж
	Бэлэн бус торгуулийн машин авах	2.5 сая	Сумын ОНХС
	“Нисдэг камер” худалдан авах	2.5 сая	ААНБ-ын хандив, тусламж
	Бичиг хэргийн зардалд	150.000	ИТХ, ЗДТГ-аас
Нийт: 5,909,000			

Гэмт хэргийн үзүүлэлт



Тав. Улаан загалмайн анхан шатны хорооны ажлын талаар

Дундговь аймгийн Улаан загалмайн хорооноос зохион байгуулсан “МУЗН-ийн ивээн тэтгэгч гишүүдийн 3-р чуулган”-д 5 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. 2017 онд онцгой гишүүнээр 5-р багийн малчин Д.Цэцэгбаяр, Ц.Долгормаа нарыг шинээр элсүүлж чуулганаар үнэмлэхийг нь гардуулав. Мөн 1-р багийн малчин УЗ-н онцгой гишүүн Г.Алтанцэцэг татвараа жил бүр тогтмол төлж “Нигүүлсэл” мөнгөн медалиар шагнагдсан. Тус чуулганаар сумын АШХ-оос 1-р багийн харьяат Сайнцагаан сумын төвд оршин суугч ахмад настан Г.Оюунд “Хүмүүнлэгийн үйлсэд хамтдаа” аяны хүрээнд 48000 төгрөгийн хүнсний зүйлээр сэтгэлийн дэм үзүүлсэн.

2017 онд сумын АШХ-оос онцгой гишүүдийн тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч шинээр 8 гишүүн элсүүлж, нийт 11 онцгой гишүүнтэй болсон байна.

Татвар төвлөрүүлэлтийн хувьд: 2017 онд сумын АШХ-оос МУЗН-ийн татварт 2'150'000 төгрөгийн татвар төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс одоогийн байдлаар 1'034'000 ₮ татвар төвлөрүүлээд байна.


2018 онд тавих зорилт:

- 1. Нутгийн удирдлагын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангана.**
- 2. Хурлын ажлын хороодыг чадавхжуулах**

АЖЛЫН АЛБА

2017.12.18

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ 1



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 8 дугаар сарын 14 ны өдрийн 36 дугаар
Тогтоолын 1 дүгээр хавсралт

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ИТХ-ААС ТАВИХ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хяналт үнэлгээний зорилт нь уул уурхайн үйл ажиллагаанаас үүсч болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, орон нутгийн оролцоо, ил тод байдлыг хангах, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж хамтын ажиллагааг үр дүнтэй байлгахад оршино.
- 1.2. ИТХ-аас хийх хяналт үнэлгээг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд батлагдсан удирдамжийн дагуу явуулна.
- 1.3. Хяналт үнэлгээг уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид туршиж үзсэн хавсралт үнэлгээний картаар хийнэ.
- 1.4. Хяналт, үнэлгээнд сумын нутаг дэвсгэрт геологи уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хамрагдана.
- 1.5. Хяналт үнэлгээнд тухайн багийн иргэдийн оролцоог хангана.
- 1.6. Хяналт үнэлгээний багийг иргэний төлөөллийг оролцуулан ИТХ-ын дарга томилно.

Хоёр. Хяналт, үнэлгээ явуулахад баримтлах зарчим

- 2.1. Хууль, тогтоомжийг эрхэмлэн дээдлэнэ.
- 2.2. Харилцааны ёс зүйг баримтлана.
- 2.3. Багаар ажиллана.
- 2.4. Ил тод, тэгш шударга байна.
- 2.5. Баримт, нотолгоонд тулгуурлана.
- 2.6. Хараат бус байна.
- 2.7. Тодорхой бус гомдол, овог нэр хаяггүй мэдээллээр явуулахгүй.

Гурав. Хяналт үнэлгээний мөрөөр зохиох ажил

- 3.1. Хяналтын үнэлгээний үр дүнг аж ахуйн нэгж, байгууллагын захиралд танилцуулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд мэдээлэл хийнэ.
- 3.2. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлийн улмаас үүссэн хохирлыг холбогдох этгээдээр барагдуулах асуудлыг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлж үр дүнг тооцно.
- 3.3. Хяналт үнэлгээний нэгдсэн тайланг уул уурхайн гурван талт хэлэлцүүлэгт мэдээлж иргэдэд нээлттэй ил, тод байлгана.

Дөрөв.. Хяналт үнэлгээний багийн үүрэг

- 4.1. Илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;
- 4.2. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- 4.3. Хяналтын үр нөлөө болон төлөөлөгчийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах
- 4.4. Хийсэн хяналт үнэлгээгээр илрүүлсэн алдаа зөрчлийн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- 4.5. Хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх буюу шилжүүлэх
- 4.6. Хяналт үнэлгээний тайлан материалыг байгууллагын архивт нэгж болгон хадгалуулах
- 4.7. Хяналт үнэлгээг байгууллагын даргын баталсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу үнэлгээний картаар гүйцэтгэнэ.

Тав. Хяналт үнэлгээний багийн эрх

- 5.1. Хяналт үнэлгээ явуулахдаа тухайн нэгжийн удирдлага, ажилтантай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутагдлын талаар тайлбар гаргуулах; алдаа, зөрчлийг арилгуулах талаар ажилчдад шаардлага тавих
- 5.2. Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг арилгах асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;
- 5.3. Хөндлөнгийн хяналтын байгууллагад хандан үзлэг, хяналт хийлгэх, заавар зөвлөгөө авах, хамтран ажиллах
- 5.4. Хяналт шалгалт хийхэд холбогдох мэргэжилтнүүдийг татан оролцуулах

Зургаа. Хариуцлага

- 6.1. Хяналт үнэлгээгээр зөрчил гаргасан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авхуулах саналыг мэргэжлийн байгууллагад хүргүүлнэ.
- 6.2. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад, хүний амь нас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхүйц байвал орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлж, шийдвэрлүүлнэ.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 2 дүгээр сарын 2 ны өдрийн
36 дугаар Тогтоолын 2 дугаар хавсралт

АШИГЛАЛТЫН ЛИЦЕНЗТЭЙ КОМПАНЫГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

	Компани дээр байх ёстой, олон нийтэд нээлттэй үзүүлэх үүрэгтэй баримт бичиг, Төлөөлөгчдөд өгөх мэдээлэл	Ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компани кемп дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд, шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд			
1.	АМТХ. 25-р зүйлийн 25.1.6. Хайгуулын ажлын явцад БО-ны менежментийн төлөвлөгөөний дагуу хүлээсэн үүргийг бүрэн биелүүлж ажилласан тухай дүгнэлт	Аймгийн МХГ-ийн дүгнэлтийг бодит байдалтай нийцүүлэн харах, актын огноог харах	
2.	АМТХ. 34-р зүйлийн 34.1. Лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлсөн эсэх	Төлбөрийн баримт огноог харах	
3.	АМТХ. 17-р зүйлийн 17.3.3. Тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газартай давхцаагүй эсэх	Газрын нэрээр асуух, солбицлолыг лавлаж харах	
4.	АМТХ. 17-р зүйлийн 17.4. Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас бага байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс харах	
5.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.1. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар огноог харж лицензийн хугацаандаа байгаа эсэхийг харах	
6.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.2. Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэл болон АМГТГ-аар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө	Төлөвлөгөө түүнийг баталсан огноо	
7.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, Нэмэлт тодотгол хийсэн бол нэмэлт тайлан	Үнэлгээ хийсэн компани, огноо	
8.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.4. БОАЖ-аар батлуулсан БОМТөлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний төлөвлөгөө тайлан.	Батлагдсан огноо түүний хэрэгжилт бодит байдал дээр	
9.	АМТХ. 35-р зүйлийн 5.3.6. Уурхайн талбайн хилийг тогтоож, байнгын шав тэмдэг тавьсан акт	Шав тэмдэг тавьсан акт болон бодит байдал дээр ямар байгааг үзэх	
10.	АМТХ. 35-р зүйлийн 35.3.7. Сумын Засаг даргатай байгуулсан ус, газар ашиглах гэрээ	Гэрээ, байгуулсан огноо, хүлээсэн үүргийн биелэлт	
11.	АМТХ. 42-р зүйлийн 42.1. Нутгийн Захиргааны байгууллагатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулсан эсэх. Уг гэрээг олон нийтээр хэлэлцүүлсэн эсэх	Гэрээ түүний хэрэгжилт, иргэдийн оролцоо хангасан эсэх	
12.	АМТХ. 43-р зүйлийн 43.1. Компанийн нийт ажиллагсад.....үүнээс.....гадаадын иргэд хэд байгаа	90%-аас дээш давсан эсэх түүний төлбөрийг суманд төлсөн эсэх	
13.	АМТХ. 39-р зүйлийн 39.1.9. Тухайн жилийн нөхөн сэргээлтийн зардлын 50%-ийг БОАЖЯ-ны тусгай дансанд хийсэн төлбөрийн баримт, эргүүлэн авсан эсэх	Төлбөрийн баримтын хуулбар огноо харах	
14.	АМТХ. 41-р зүйлийн 41.1.1. Ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Бодит байдал, иргэдийн мэдээлэлтэй харьцуулж нягтлах	
15.	АМТХ. 69-р зүйлийн 39.1.7. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан сөрөг	Бодит байдал Засаг даргад танилцуулсан баримтуудыг үзэх	

	нөлөөлийг тухай бүр бүртгэж, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний тайланг сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлсэн баримт бүртгэл	түүнд Засаг даргын өгсөн хариу	
16.	АМТХ. 48-р зүйлийн 48.10. Тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж мэдээлсэн, хандив тусламж хэд хэнд өгсөн, ямар дансанд орсон, баталгаажуулсан байдал	
17.	БОНБҮТХ. 18-р зүйлийн 18.4. Төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.	БОНБНҮ-ний тайлангаас Санал хэрхэн авсан, хэлэлцүүлэгээс ямар санал гарсан тайланд хэрхэн тусгасан байдлыг харна.	
18.	БОНБҮТХ. 14-р зүйлийн 14.1.2. байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах	Хэрэгжилтийг тайлан, түүнийг олон нийтэд хэрхэн танилцуулсантай тулгаж он оноор үзэх	
19.	ГТХ. 5-р зүйлийн 51.2. Төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж байршуулах, үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой болон бусад бодисыг газрын дор хадгалах, булах зөвшөөрөл	Хэрэгжилтийг газар дээр нь нарийвчлан үзэх	
20.	УТХ. 30 дугаар зүйл. Ус ашигласны болон бохирдуулсны төлбөр төлсөн баримт жил бүрээр	Төлбөрийн баримт бичиг	
21.	ГХТХ. 8-р зүйлийн 8.1.4. /ашигт малтмалын ордыг ашиглах үед үржил шимтэй хөрсийг тусгайлан хуулж ашиглах буюу хадгалсан байх	Засаг даргатай байгуулсан газар ашиглах гэрээнд хэрхэн тусгасан бодит байдал	
22.	ГХТХ. 32-р зүйлийн 32.8. Ажиллагчид болон хүн амын аюулгүй байдлыг хангах, газрын хэвлий, байгаль орчны бусад объект, барилга байгууламжийг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх, аюул ослын үр дагаврыг арилгах төлөвлөгөө байгаа эсэх, батлуулсан огноо	Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг үзэх	
23.	БОХТХ. 31-р зүйлийн 31.4 байгаль орчинд сөрөг нөлөөлөл бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг ААН, байгууллага үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх	Тусгасан төсвийн зарцуулалт нөхөн сэргээлтийн үр дүнтэй харьцуулан үзэх	
24.	БОХТХ. 49-р зүйлийн 48.1. Иргэн ААН, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлнө.	Байгаль хамгаалагч төлбөр тавьсан бол түүнийг төлсөн төлбөрийн баримт огноо	
25.	БОХТХ. 55-р зүйлийн 55.2.2. Эрхийн бичиг, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан болон зөвшөөрөлгүй агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг болон зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн хог хаягдал, бусад бодис гаргахад нөхөн төлбөр ногдуулна.	Хэтрүүлсэн хог хаягдал, бусад бодис гаргасныг ажиглах, түүний хэтрэлтэд БОУ-ын байцаагчийн хяналт төлбөрийн баримт бичиг	
26.	Ажилчдын эрх ашгийг хамгаалах Үйлдвэрчний эвлэл байдаг эсэх, түүний үйл ажиллагаатай танилцах	Ажилчдаас мэдээлэл авах	
27.	ТХШТХ-ийн 7.2. ААН, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг эсэх, хариуцсан ажилтан байгаа эсэх	Дотоод журам үзэх, ажилтантай уулзах	
28.	ГХТХ. Газрын хэвлийг ашиглах явцад илэрсэн түүх,	Асуулт хариултаар мэдээлэл	

	соёлын онцгой үнэт зүйл, олдворыг зохих байгууллагад мэдэгдсэн	авах	
В. Тухайн компанитай холбоотой мэдээллийг ЗДТГ түүний холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавих замаар үзэж болох баримт бичгүүд/шалгах асуултууд/			
1.	АМТХ.38-р зүйлийн 38.1.6. БОХ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх төлөвлөгөөг Засаг даргаар батлуулсан эсэх	Төлөвлөгөөг Засаг дарга баталсан эсэх, хэрэгжилтийг газар дээр нь үзэх	
2.	АМТХ.41-р зүйлийн 41.1.Лиценз эзэмшигч нь үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж, түүх соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид нь нөхөн төлсөн эсэх, тэдгээрийг шилжүүлэн байршуулахтай холбоотой зардлыг хариуцсан эсэх	Нөхөн төлбөр олгосон мэдээлэл, гарын үсэг, иргэдтэй байгуулсан гэрээ,нөхөн олговор олгох зэрэглэл, тогтоосон байдал, үнэлгээ хийсэн эсэх, гарын үсэг, тамга тэмдэг бүхий баримт үзнэ.	
3.	АМТХ.42-р зүйлийн 42.1.Лиценз эзэмшигч нь БОХ, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар гэрээ байгуулсан эсэх	Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт	
4.	АМТХ.48-р зүйлийн 48.10.тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Хэрхэн мэдээлсэн, хэвлэн тараасан уу, Малчин ажилгүй байгаа хүн,сумын ажилгүйчүүд, ядуучуудад яаж мэдээлсэн мэдэж байгаа эсэх	
5.	БОНБҮТХ.9 –р зүйл. БОНБҮ-ний Засаг даргад болон БОУ-ын байцаагчид байгаа эсэх	Үнэлгээний хувийг үзэх	
6.	БОНБҮТХ.9 –р зүйл.9.12. БОМен-ийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, улсын байцаагч, Засаг даргын хяналт тавьж байгаа байдал	Тодорхой төлөвлөгөөтэй тогтсон хяналт тавьж байна уу. Хяналт хийсэн тэмдэглэл түүний мөрөөр авсан арга хэмжээг баримтаас үзэх	
7.	ГТХ. 55 дугаар зүйлийн 55.5. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцэж, дүгнэсэн баримт	ИТХ-ын тэмдэглэл	
8.	БОХТХ.10-р зүйлийн 10.1. Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа ААН, байгууллага нь 2 жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймгийн байгаль орчны албанд хүргүүлнэ.	2 жил тутамд хийгдсэн тайлан түүний баталгаажуулалт	
9.	БОХТХ.17-р зүйлийн 2.4. нутаг дэвгэрийнхээ ААН, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харъяалал харгалзахгүйгээр хянаVVV.лт тавьж, орчинд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, хортой нөлөөллийг түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх	Засаг даргын үүргийн биелэлтийг сонсох	
10.	БОХТХ.17-р зүйлийн 2.6. 17.2.6.ААН,байгууллагын хог хаягдлын цэг тогтоох, бохирдлыг багасгах арга хэмжээ авах	Хэрэгжилтийн тайлан мэдээлэл	
11.	БОХТХ.18-р зүйлийн 1.3..Байгаль орчныг хамгаалах талаархи Засаг даргын ажлын тайлан сонсох	БИНХ-аас асуух баримт авах	
12.	БОХТХ.18-р зүйлийн 2.2.нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах ажлыг удирдан чиглүүлж, орчны бохирдол, хог хаягдлыг цэвэрлэх жил бүрийн ажилд иргэдийг татан оролцуулах	Багийн засаг даргаас асуух, тайлан баримтыг авч үзэх	

Үнэлгээ хийсэн:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 2 дүгээр сарын 2 ны өдрийн
36 дугаар Тогтоолын 3 дугаар хавсралт

ХАЙГУУЛЫН ЛИЦЕНЗТЭЙ КОМПАНИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ КАРТ

Өлзийт сум

	Компани дээр байх ёстой, нийтэд нээлттэй баримт бичиг	Үнэлгээнд ашиглах мэдээллийн эх сурвалж	Хяналтын тэмдэглэл
А. Компанийн кемп дээр очиж үзэх боломжтой баримт бичгүүд/ шалгах асуултуудтай холбоотой хуулийн заалтууд			
1	АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.4. Лиценз авах хүсэлтийг аймаг, нийслэлийн Засаг даргад бичгээр мэдэгдэх эсэх, түүнд ИТХ хугацаандаа санал өгсөн эсэх буюу лиценз нь хуулийн дагуу олгогдсон эсэх	ИТХ- д албан бичиг ирсэн, хариу өгсөн огноог бичиг хэргийн хөтөлгөөнөөс харах	
2	АМТХ. 17 дүгээр зүйлийн 17.4. Лицензийн нийт талбайн хэмжээ 25 га-аас их, 150 га-аас их биш байгаа эсэх	Лицензийн гэрчилгээнээс бодит байдлыг хэмжиж үзэх	
3	АМТХ. 34 дүгээр зүйлийн 34.1. Хайгуулын лиценз авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан лицензийн төлбөрөө төлсөн баримт	Төлбөрийн баримт үзэх	
4	АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.8. Хайгуулын лицензийн хугацаа: хэд дэх жилхэд дэх сунгалттай байгаа ²⁰	Лицензийн гэрчилгээ, хуулбараас үзэх	
5	АМТХ. 35 дугаар зүйлийн 35.3.1. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбар	Хуулбар	
6	АМТХ. 35 дугаар зүйлийн 35.2.2. Засаг даргаар батлуулсан жил бүрийн БО-ны менежментийн төлөвлөгөө, түүний биелэлтийн тайлан	Тайлангийн хэрэгжилтийг газар дээр нь шалгаж төлөвлөгөөтэй тулгаж харах	
7	АМТХ. 35 дугаар зүйлийн 35.2.3. АМГТГ болон МХЕГ-аар хянуулсан хайгуулын ажлын төлөвлөгөө, урд жилийн тайлан	Ажлын төлөвлөгөөний хянуулсан огноо	
8	АМТХ. 38 дугаар зүйлийн 38.1.8. БО-ыг нөхөн сэргээхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг сумын Засаг даргын тусгай санд байршуулсан баримт, нөхөн сэргээлт хийж буцааж дэнчинг авсан эсэх	Жил бүрийн баримтыг үзэх	
9	АМТХ. 41 дүгээр зүйлийн 41.1. Хайгуулын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг хэрхэн шийдвэрлэсэн	Баримтуудыг үзэх, асуулт тавиж хариулт авах, кейс дээр жишээ авч хариулт авах	
10	АМТХ. 42 дугаар зүйлийн 42.1. Нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажилласан байдал	Гэрээг үзэх, Иргэд, ИНБ-ын оролцоог хангасан байдал	
11	АМТХ. 48 дугаар зүйлийн 48.10. Тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөр, биет болон биет бус хандивын хэмжээний тайлан, түүнийг олон нийтэд мэдээлсэн эсэх, хэрхэн яаж	Тайлагнасан эсэх, Таилагнасан хэлбэр	
12	АМТХ. 35 дугаар зүйлийн 35.3.7. Сумын засаг даргаас газар, ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулсан эсэх	Газар ус ашиглах гэрээ хийгдсэн огноо. Усны төлбөр тогтоосон дүгнэлтийн хамт	
13	АМТХ. Хайгуулын ажлын явцад нөхөн сэргээлт хийсэн эсэх, түүнийг хүлээж авсан дүгнэлт, түүнд иргэдийн төлөөллийг оролцуулсан эсэх	Нөхөн сэргээлт хүлээн авсан комиссын акт, нутгийн иргэдээс хэн хэн байна	
14	ТХШТХ-ийн 7.2. Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоолын дагуу Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам	Дотоод журам үзэх, ажилтантай уулзах	

	батлуулан мөрдөж ажилладаг эсэх хариуцсан ажилтан байгаа эсэх		
В. Тухайн компанитай холбоотой холбогдол мэдээллийг Засаг дарга болон холбогдох албан тушаалтанд асуулга, асуулт тавих замаар шалгах асуултууд			
1	АМТХ. 19 дүгээр зүйлийн 19.4.Аймгийн Засаг даргад хүсэлт ирснээс хойш 30 хоногийн дотор хүргүүлсэн албан хариу өгсөн байдал	ЗДТГ-ын ирсэн явсан бичгийн хөтөлгөө болон хурлын тэмдэглэлээс харах	
2	АМТХ. 38 дугаар зүйлийн 38.1.6. БОХ талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, хайгуулын ажилд ашигласан шинэ техник, технологи, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэх төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулсан эсэх	Төлөвлөгөөг үзэх түүнийг Засаг дарга баталсан эсэх, түүний хэрэгжилтийг газар дээр нь үзэх	
3	АМТХ. 41 дүгээр зүйлийн 41.1. Лиценз эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцсан эсэх	Нөхөн олговор олгосон мэдээлэл гарын үсэг, иргэдтэй байгуулсан гэрээ, зэрэглэл тогтоосон байдал, үнэлгээ хийсэн байдлыг биежүүлсэн эсэх, гарын үсэг тамга тэмдэг бүхий баримт бичгүүдийг үзнэ	
4	БОНБҮТХ. 9 дүгээр зүйлийн 9.12. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинэжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа байдал	Хяналт хийсэн тэмдэглэл, түүний мөрөөр авсан арга хэмжээг бичиг баримтаас үзэх	
5	БОНБҮТХ. 8 дугаар зүйлийн 8.4.8. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл	БОНБҮ-ний тайлангаас үзэх	
6	ГТХ. 55 дугаар зүйлийн 55.5. Газрыг хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны ИТХ-аар хэлэлцэж, дүгнэсэн баримт	ИТХ-ын хуралдааны тэмдэглэл	
	Дүгнэлт:		

Үнэлгээ хийсэн:

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ 2

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2017 оны 12 дугаар сарын 1-ны
өдрийн 2.Ү. дүгээр Тогтоолын 1 дүгээр
хавсралт

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНД АСУУДАЛ САНААЧЛАН ОРУУЛАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг журам

1.1. Энэхүү журмаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид "Хурал" гэх/- ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанд Хурлын төлөөлөгч, хороо, нам, эвслийн бүлэг, Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж хэлэлцүүлэх асуудлыг зохицуулна.

Хоёр. Асуудал санаачлан оруулах, санал дэвшүүлэх эрх

2.1. Хурлын төлөөлөгч, ажлын хороо, нам, эвслийн бүлэг, Засаг дарга асуудал санаачлан Хуралд хэлэлцүүлэхээр оруулах эрхтэй.

2.2. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

2.3. Багийн Иргэдийн Нийтийн хурлаас сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

Гурав. Асуудал санаачлан оруулах, санал дэвшүүлэх

3.1. Хурлын төлөөлөгч, ажлын хороо, нам, эвслийн бүлэг, Засаг дарга Хурлын хуралдаан, Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал санаачлан хэлэлцүүлэхээр бол тухайн Хурлын хуралдаан зарлагдахаас 16 хоногийн өмнө, Тэргүүлэгчдийн хуралдаан зарлагдахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө дараахь баримт бичгийг ирүүлнэ:

3.1.1. Тогтоолын төсөл /цаасаар болон файлаар/;

3.1.2. Хэлцэх асуудал боловсруулсан үндэслэл, шаардлага;

3.1.3. Холбогдох санхүүгийн тооцоо;

3.1.4. Судалгаа, лавлагаа, тайлбар;

3.1.4. Шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагын санал.

3.1.5. Сонсох ажиллагааг заавал зохион байгуулсан байна. Үүнд: Ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй талуудтай:

- а. Сонсгол зохион байгуулах;
- б. Саналыг бичгээр авах;
- в. Биечлэн уулзах;
- г. Утсаар санал авах;
- д. Цахим хэлбэрээр санал авах;
- е. Төлөөлөгчөөр дамжуулан санал авах;
- ё. Бусад.

3.2. Хурал өөрийн дотоод асуудлыг хэлэлцэхэд бусад байгууллагын саналыг шаардахгүй байж болно.

3.3. Хурлын дотоод асуудлаас бусад чиглэлээр асуудал хэлэлцүүлэхээр санаачилсан тохиолдолд Засаг даргын саналыг авна. Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан санал өгөх бөгөөд санал өгөөгүй бол зөвшөөрсөнд тооцно.

3.4. Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийн бүрдэл хангагдсан, Хурлын дарга, Тэргүүлэгчид зөвшөөрөл өгсөн тохиолдолд тухайн хуралдаан болохоос 1 хоногийн өмнө Хурлын төлөөлөгчид, эсхүл Тэргүүлэгчдэд тараах бөгөөд уг шаардлагыг хангаагүй асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

Дөрөв.Хуралдаанд асуудлыг танилцуулах

4.1. Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн болон Ажлын хорооны хуралдаанд тухайн асуудлыг санаачилсан төлөөлөгч, Засаг дарга, ажил хариуцсан албан тушаалтан танилцуулна. Шаардлагатай тохиолдолд хуралдаанд асуудал боловсруулсан ажлын хэсгийн гишүүн, төрийн албан хаагч хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр оролцож, тайлбар хийж, асуултад хариулж болно.

4.2. Шаардлагатай бол Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тухайн асуудал эрхэлсэн хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар урьдчилан хэлэлцэж, санал дүгнэлт, санал хураалгах саналын томъёоллыг бэлтгэн хуралдаанд оруулна.

4.3. Асуудал санаачилж байгаа субъект Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, иргэд, олон нийтийн саналыг авах хэлэлцүүлэг зохион байгуулж болно.

4.4. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан урилгаар оролцуулах албан тушаалтан, иргэдийн нэрсийг ажлын алба гаргаж мэдэгдэнэ.

4.5. Хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр санаачилсан болон санал тавьсан субъект нь тухайн асуудлыг Хуралдааны танхимаас өөр газар явуулын хуралдаан журмаар хуралдуулах санал тавьж болно.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2017 оны 23 дугаар сарын 15 ны
өдрийн 24 дүгээр Тогтоолын 2 дугаар
хавсралт

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ АСУУЛГА, АСУУЛТ
ТАВИХ, ХАРИУГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /цаашид “Хурал” гэх/-ын төлөөлөгчөөс Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан холбогдох албан тушаалтанд асуулга болон асуулт тавьж хариуг өгүүлэх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр.Хурлын төлөөлөгч асуулга тавих

2.1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д заасныг үндэслэн Хурлын төлөөлөгч нь Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах эрхтэй.

2.2. Хурлын төлөөлөгч асуулга / албан бичгийн хэвлэмэл хуудсаар 3 хувь бичиж/-ын төслөө боловсруулан Хурлын ажлын албанд ирүүлнэ.

2.3. Хурлын ажлын албаны ажилтан асуулгын төслийг албажуулан, нэг хувийг Хурлын төлөөлөгчид, нэг хувийг холбогдох албан тушаалтанд, нэг хувийг албан хэрэгтээ бүртгэж хадгална.

2.4. Асуулгыг цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байрлуулна.

2.5. Асуулга хүлээж авсан албан тушаалтан 10 хоногийн дотор хариуг бичгээр өгнө.

2.6. Хурлын ажлын албаны ажилтан асуулгын хариуг хугацаанд нь ирүүлж байгаад хяналт тавьж ажиллана.

Гурав.Хурлын төлөөлөгчийн тавьсан асуулгын хариуг хэлэлцэх

3.1. Хурлын төлөөлөгч асуулга тавих, түүний хариуг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д заасныг үндэслэн дараахь байдлаар хэлэлцэнэ:

3.1.1. Төлөөлөгч асуулгын хариуг Хурлын хуралдаан, ажлын хорооны хуралдаан, Багийн Иргэдийн Нийтийн Хуралдаанаар хэлэлцүүлж болно. Төлөөлөгч асуулгын хариуг Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх бол энэ тухайгаа Хурлын даргад таваас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

3.1.2. Асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан төлөөлөгч нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ.

3.2. Төлөөлөгчийн асуулгыг нам, эвслийн бүлгийн хурлаар хэлэлцүүлэхгүй бөгөөд зөвхөн Хурлын хуралдаанаар хэлэлцэнэ. Хурлын хуралдаанаар хэлэлцэх асуудлын дараалалд оруулах эсэхийг Хурлын Тэргүүлэгчид хуралдаанаараа шийдвэрлэнэ.

3.3. Асуулгын хариуг олон нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Хурлын төлөөлөгч асуулт тавих

4.1. Хурлын төлөөлөгч Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулт тавьж хариуг нь авах эрхтэй.

4.2. Асуултыг хүлээн авсан албан тушаалтан хариуг 10 хоногийн дотор төлөөлөгчид бичгээр өгнө.

4.3. Хурлын төлөөлөгчийн тавьсан асуултыг албажуулах, холбогдох албан тушаалтанд хүргүүлэх, хариуг хэлэлцэх журам нь асуулга тавихтай нэгэн адил байна.

4.4. Шаардлагатай гэж үзвэл асуултын хариуг Ажлын хорооны хуралдаанд танилцуулж, тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамтаар Хурлын даргад уламжилж болно.

4.5. Төлөөлөгчөөс тавьсан асуултын хариуг иргэдэд мэдээлж болно.